



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/4

Булган

Хүүхэд харах үйлчилгээг шилжүүлэх Ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 20 дугаар зүйлийн 20.1, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/011, А/020 тоот хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хуульд заасны дагуу хүүхэд харах үйлчилгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан ажил хүлээлцэх ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний дотор зохион байгуулсугай.

2. Ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Э.Түвшинмөнх/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Б.Эрдэнэбаатар/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /Т.Баярбат/ нарт тус тус даалгасугай.

4. Ажил хүлээлцсэн тухай тайланг 2018 оны 02 дугаар сарын 08-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Э.Түвшинмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 сарын
..... ний өдрийн А/... дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Э.Түвшинмөнх – Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: М.Батчимэг Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Эрдэнэбаатар – Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Т.Баярбат – Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Н.Мөнхтуяа – БСУГ-ын сургуулийн өмнөх боловсролын асуудал
хариуцсан мэргэжилтэн

Д.Алтаншагай – БСУГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээ
хариуцсан мэргэжилтэн


Г.Ихбаяр - БСУГ-ын төсвийн мэргэжилтэн

Д.Батмөнх - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах
мэргэжилтэн

С.Оюунзаяа- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хяналт-
шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Х.Булган - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодогч

Нарийн бичиг: О.Буянбат - Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Чиглэл:

1. Хүүхэд харах үйлчилгээнд мөрдөгдөж байгаа хууль, журам, стандарт, сургалтын гарын авлага материалыг хүлээлцэх
2. Хүүхэд харах үйлчилгээний санхүүгийн тайланг хүлээлцэх
3. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч болон хүүхэд харах үйлчилгээнд хамрагдагч хүүхдүүдийн бүртгэлийн баримт бичиг хүлээлцэх
4. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч болон хүүхэд харах үйлчилгээнд хамрагдагч хүүхдүүдийн тоон статистикийг хүлээлцэх
5. Ажлын хэсэг хүүхэд харах үйлчилгээг шилжүүлж, хүлээлцсэн тухай нэгдсэн тайлан, илтгэх хуудсыг харьяалах дээд шатны байгууллагууддаа 2018 оны 01 дүгээр сарын 31-ний дотор хүргүүлэх

№	Хүлээлцсэн баримт бичгийн нэр	Хүлээн авсан он сар өдөр	Тэмдэглэгээ	Хүлээлгэн өгсөн албан тушаалтан	Хүлээн авсан албан тушаалтан
1	Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, журам, стандарт /цахим хэлбэрээр/				
2	Хүүхэд харагчдын чадавхжуулах сургалтын гарын авлага /цахим хэлбэрээр/				
3	Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй иргэдийн мэдээллийн сан /цаасан болон файлаар/				
4	Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн мэдээллийн сан /цаасан болон файлаар/				
5	Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтийн тайлан /цаасан болон файлаар/				
6	Хүүхэд харах үйлчилгээний хаяг, байршлын жагсаалт /цаасан болон файлаар/				
7	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, үнэлгээний тайлан, зөвлөмж /цаасан болон файлаар/				

Ажил хүлээлцэх маягтын загвар